

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАРТ 2016 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БАЙДЛААР ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА**

Санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй тус Хорооны зохицуулалтын салбар болох үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 20-ний өдөр буюу 2016 оны хагас жилийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд судалгаа, дүн шинжилгээг хийлээ.

Тайлант хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 284 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс салбар тус бүрээр ангилбал:

Үнэт цаасны салбарт – 116

Даатгалын салбарт – 121

Бичил санхүүгийн салбарт – 47 өргөдөл, гомдол тус тус ирүүлсэн байна.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг салбар тус бүрээр графикаар харуулбал:





График 1

2015 оны эхний хагас жилд тус газарт ирсэн өргөдөл, гомдлын тоог 2016 оны энэ үетэй харьцуулбал:

График 2



Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:

Хяналт шалгалтын газарт тайлант хугацаанд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 284 өргөдөл, гомдол ирснээс:

Шийдвэрлэх шатандаа байгаа - 23 өргөдөл, гомдол байна. Үүнээс:

Хугацаандаа, судлагдаж байгаа өргөдөл, гомдол - 23

Хугацаа хэтрэн судлагдаж байгаа өргөдөл – 0

Шийдвэрлэж, хариу өгсөн – 261 өргөдөл, гомдол байна. Үүнээс:

Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл – 260

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл – 1

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа **18 хоног** байна.

Хамгийн богино хугацаа – 2 хоног

Хамгийн урт хугацаа – 84 хоног

Шийдвэрлэлтийн хугацааг салбараар ангилвал /хоног/:

Үнэт цаасны салбарын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа – 22

Даатгалын салбарын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа – 14

Бичил санхүүгийн салбарын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа – 17

Өргөдөл шийдвэрлэлтийн процесс, авах арга хэмжээний цар хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран шийдвэрлэлтийн хугацаа өөр өөр байгаа хэдий ч шийдвэрлэлтийн дундаж хугацааг богиносгох зорилготой ажиллаж байна. Үнэт цаасны салбарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа нэгдүгээр улирал 17

хоног байсан нь 22 хоног болж нэмэгдсэн нь үнэт цаасны арилжаатай холбоотой анхан шатны баримт гаргагч байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2016 оны 4 дүгээр сарын 11–ний өдрөөс 2016 оны 5 дугаар сарын 14–ний өдрийг хүртэл буюу нэг сарын хугацаанд архивын баримт гаргах боломжгүй байсан тул шийдвэрлэлтийн хугацаанд нөлөөлсөн байна.

1. Үнэт цаасны салбарт ирсэн өргөдөл, гомдол:


Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 116 өргөдөл, гомдол ирснээс 109 өргөдөлд хууль, журмын дагуу хянаж холбогдох хариуг өгсөн бөгөөд 7 өргөдөл хяналтын шатандаа судлагдаж байна.

Тус газарт ирсэн Үнэт цаасны салбарын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног байна. Өргөдөл, гомдол шийдвэрлэхэд “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТХТ” ХХК, үнэт цаасны компани болон шаардлагатай тохиолдолд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг байгууллагуудаас тогтмол тайлбар, материалыг гаргуулан авч ажилладаг.

Дээрх өргөдөл, гомдолд хувьцаат компанийн ногдол ашиг, хувь болон үйл ажиллагаа, үнэт цаасны бүртгэлтэй, брокер, дилерийн компаниар эзэмшигчийн зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаатай холбоотой өргөдлүүд тус тус ирсээр байна.

Нийт ирсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилвал:

График 3



Үнэт цаасны салбарт ирж буй нийт өргөдлийн 63% нь эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байгаа бөгөөд үүнээс 43% нь тус Хорооны тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 12 брокер, дилерийн компаниудаар дамжуулан арилжаалагдсан гэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон 15 брокер, дилерийн компаниар дамжуулан хийгдсэн гэх өргөдөл, гомдол 57%-ийг эзэлж байна.

Тайлант хугацаанд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж дараах мэргэжлийн оролцогч байгууллагуудад харилцагчдын хохирлыг барагдуулах үүрэг өгч заасан хугацаанд үүргийн биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Хүснэгт 1 /төгрөгөөр/

№	Компанийн нэр	Харилцагчийн тоо	Хохирлын дүн	Төлөгдсөн хохирлын дүн
1	"Санар" ХХК	3.00	9,829,247.00	2,110,952.00
2	"Бумбат алтай" ХХК	1.00	11,500.00	11,500.00
3	"Батс" ХХК	1.00	20,000.00	20,000.00
4	"Масдак" ХХК	1.00	466,495.00	466,495.00
5	"Аргайбэст" ХХК	2.00	5,872,140.00	4,210,000.00
	Нийт	8.00	16,199,382.00	6,818,947.00


2015 онд харилцагчдын хохирлыг барагдуулахаар мэргэжлийн оролцогч компаниудад 24,748,120.00 төгрөгийг төлүүлэх үүрэг өгснөөс 13,402,740.00 төгрөгийг төлүүлж нэг харилцагчийн 11,335,000.00 төгрөгийг төлүүлэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Дээрх зөвшөөрөлгүй арилжаалагдсан гэх үйлдэл нь 1996 оноос 2009 онуудын хооронд хийгдсэн байх бөгөөд 1996 оноос 2002 онуудад хийгдсэн гүйлгээтэй холбоотой өргөдөл дийлэнх хувь буюу 62%-ийг эзэлж байна.

Мөн зөвшөөрөлгүй зарагдсан гэх өргөдөл, гомдлын 57% нь тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон үнэт цаасны компаниар дамжигдан арилжаалагдсан, харин 43% нь тусгай зөвшөөрөл нь хүчинтэй үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудаар дамжигдан арилжаалагдсан байна.


Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үнэт цаасны компаниудад хандан ирүүлсэн нийт өргөдөл, гомдлыг доорх графикаар харууллаа:

График 4



Харин тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон Хорооны зохицуулалтаас гарсан үнэт цаасны компаниудад хандан ирүүлсэн өргөдөл, гомдлыг хувьчлан харуулбал:

График 5



Мөн хувьцаат компанийн бүртгэл болон хаяг байршил, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэртэй холбоотой асуудлаар, ногдол ашгийн талаарх мэдээлэл авахыг хүссэн өргөдөл, гомдлууд аж ахуй нэгж болон иргэдээс ирүүлсээр байна.

2. Даатгалын салбарт ирсэн өргөдөл, гомдол:


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 262 дугаар тогтоолоор батлагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд даатгалын салбарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргаан, өргөдөл гомдол 2016 оны хагас жилийн байдлаар нийт 121 ирж үүнээс 114 өргөдөл гомдол хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэгдсэн бөгөөд 7 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Дээрх өргөдөл гомдлыг даатгалын бүтээгдэхүүний төрлүүдээр авч үзвэл Жолоочийн хариуцлагын албан журмын, Автотээвэр буюу Тээврийн хэрэгслийн, Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн, Тээвэрлэгчийн хариуцлагын, Ажилчдын гэнэтийн ослын, Мэргэжлийн хариуцлагын, Бизнес эрхлэгчдийн цогц даатгал болон даатгалын хохирол үнэлгээний тайлан, дүнг шалгуулах, тус Хорооноос батлагдсан дүрэм, журмыг хэрхэн ойлгох талаар Даатгалын компаниудаас ирүүлсэн хүсэлтүүдийг хуулийн дагуу хянан шийдвэрлэж нийт 124,451,698.00 /нэг зуун хорин дөрвөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга зургаан зуун ерэн найм/ төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг төлүүлж ажилласан байна.

Даатгалын салбарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг графикаар харьцуулж харуулбал. Үүнд:

2016 оны эхний хагас жилд ирсэн өргөдөл, гомдлын харьцааг давхардсан тоогоор харуулав.

График 6



2016 оны нэг, хоёрдугаар улиралд Хяналт шалгалтын газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг доорх графикаар харьцуулалт хийж харуулав.





График 7

2016 оны эхний хагас жилд даатгалын салбарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүн төрлүүдээр ангилан харуулбал Жолоочийн хариуцлагын, албан журмын даатгал 35 хувь буюу хамгийн өндөр байх бөгөөд Тээврийн хэрэгслийн даатгал 26 хувь, харин даатгалын бусад асуудлаар 21 хувийг эзэлж байна.

Харьцуулалтыг график 8-д харуулав.

График-8

- Жолоочийн хариуцлагын, албан журмын даатгал - 43
- Тээврийн хэрэгслийн даатгал - 32
- Орон сууцны зээлийн даатгал /Ипотек/ - 14
- Малын даатгал - 2
- Даатгалын хураамж - 2
- Ажилчдын гэнэтийн ослын даатгал - 2
- Бусад-26



2016 оны эхний хагас жилд даатгалын салбарт иргэн, аж ахуйн, нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь урьдчилан шийдвэрлэж нийт 124,451,698.00 (зуун хорин дөрвөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга зургаан зуун ерэн найм) төгрөгийг төлүүлэн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалж ажилласан байна.

- Талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэж нөхөн төлбөр төлүүлсэн дүнг Даатгалын компани бүрээр гаргаж доор хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2 /төгрөгөөр/


№	Компанийн нэр	Төлөгдсөн нөхөн төлбөрын дүн
1	"Ард даатгал" ХХК	28,292,000.0
2	"Бодь даатгал" ХХК	10,278,138.0
3	"Монре даатгал" ХХК	10,792,000.0
4	"Монгол даатгал" ХХК	9,989,500.0
5	"Миг даатгал" ХХК	29,753,280.0
6	"Мандал женерал даатгал" ХХК	18,662,300.0
7	"Соёмбо даатгал" ХХК	1,111,000.0
8	"Хаан даатгал" ХХК	3,610,600.0
9	"Практикал даатгал" ХХК	9,862,000.0
10	"Номин даатгал" ХХК	2,100,880.00
	Нийт	124,451,698.0

3. Бичил санхүүгийн салбарт ирсэн өргөдөл, гомдол:

Бичил санхүүгийн салбарт 2016 оны нэгдүгээр улиралд 22, хоёрдугаар улиралд 25, нийт 47 өргөдөл, гомдол ирүүлсэн байна. Үүнээс банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 21, хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой 20, бусад үйл ажиллагаатай холбоотой 6 өргөдөл, гомдол тус тус ирсэн байна.


Үүнийг графикаар харуулбал.

График-9



Тухайн салбарт ирсэн нийт өргөдөл, гомдлын тоог 2016 оны эхний хагас жил, 2015 оны эхний хагас жилтэй харьцуулвал:

График-10



Хоёрдугаар улиралд ирсэн өргөдөл гомдлын тоог нэгдүгээр улиралд тус салбарт иргэдээс ирсэн өргөдөл гомдлын тоотой харьцуулахад 12%-р өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны хувьд Нийслэлийн төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж буй төслийн хүрээнд орж ирсэн мөнгийг хэрхэн зарцуулж байгаа болон бусад асуудлууд дээр ХЗХ-ны удирдах албан тушаалтан болон гишүүдийн санал зөрөлдөх, зээл олгоходоо хүүг урьдчилан суутгадаг, барьцаа хөрөнгөтэй холбоотой асуудлууд их гарч байна.

ББСБ-уудын хувьд өргөдөл, гомдлын дийлэнх хувийг зээлийн барьцаа хөрөнгийг буцаан олгох болон барьцаанаас чөлөөлөөгүй, хувь хүний мэдээллийг олон нийтэд задруулсан, зээлийн алданг буруу бодсон асуудлууд эзэлж байна. Мөн зээлээ бүрэн төлж барагдуулсан зээлдэгчдийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд тухай бүр шинэчлэн хүргүүлдэггүй, ББСБ-уудын зээлийн хүүгийн хэмжээ өндөр, зээлийн графикт тусгагдаагүй хүүг урьдчилж авдаг гэх мэт асуудлуудыг холбогдох хууль, журмын дагуу тухайн ББСБ-д албан бичиг хүргүүлэн арга хэмжээ авч ажиллалаа.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ,
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТЭС**